

Гарчиг

1.Танилцуулга

Идэвхитнүүдийн гарын авлага

2. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажил

3.Заавал мөрдөх зүйл: Өөрчлөх арга хэрэгсэл

4. Заавал мөрдөх зүйлийг кампанит ажлын арга хэрэгсэл болгох нь

Нэгдүгээр шат: Өөрийн орны нөхцөл байдлыг тодорхойлох
Үндэсний хууль тогтоомжинд дүн шинжилгээ хийх
Олон улсын хүний эрхийн хууль
Олон улсын хүмүүнлэгийн болон эрүүгийн хууль
Дэлхий нийтийн хүний эрхийн чиг хандлага

Хоёрдугаар шат: Гадаад болон дотоод нөхцөл байдлыг тодорхойлох
Эмэгтэйчүүдийн байгууллага гол үүрэг гүйцэтгэх нь
Эрчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
Бусад холбоотон

Гуравдугаар шат: Асуудлыг гаргаж тавих
Загвар А: Хууль зүйн өөрчлөлт
Загвар В: Бодлого, бодит байдлыг өөрчлөх
Загвар С: Олон нийтийн хэлэлцүүлэг хийх
Загвар D: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл дээр ажиллах өөрийн
байгууллагын чадавхийг сайжруулах

Дөрөвдүгээр шат: Шийдвэрлэх аргыг тогтоох

Тавдугаар: Зорилтот бүлгээ тодорхойлох, тэдэнд хүрч ажиллах

Зургадугаар шат: Кампанит ажлын загварыг гаргах

Долдугаар шат: Үнэлгээ ба хариу илтгэл

4. Дүгнэлт

Хавсралт 1

Хавсралт 2



Өмнөх үг

Уг товхимолыг эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, хүндэтгэх, биелүүлэх тал дээр олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг өөрийн орны эрх баригчдаас шаардан охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажил өрнүүлэхэд танд туслах зорилгоор гаргалаа.

Энэ ном нь хүний эрхийн төлөө тэмцэгч, эмэгтэйчүүдийн байгууллага, хүний эрхийн байгууллага болон Эмнести Интернэшнлийн салбаруудад зориулагдсан бөгөөд кампанит ажлыг үе шаттайгаар зохион байгуулахад хөтөч болох учиртай юм.

Үйл ажиллагаанууд нь холбогдох байгууллагуудад илүү ойр дөхөм, зарим санаа санаачлагууд улс оронд өгөөжтэй, амьдрад илүү нийцтэй байж болох тул та эдгээрийг өөрийнхөө байгууллага болон өөрийн орны тодорхой соёл, хууль, нийгмийн нөхцөл байдалд тохируулан авч хэрэглэх боломжтой.

Алхам алхамаар хэмээх энэхүү хөтөч нь бидэнд тулгарч буй бодит жишээнүүд дээр тулгуурласан билээ.

Идэвхитнүүдийн цуврал гарын авлага:

Энэ нь идэвхитнүүд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөө нийтэд дуу хоолойгоо хүргэхэд зориулагдсан.

Нэгдүгээр хэсэгт нь жендэр болон эмэгтэйчүүдийн эрхэд тулгуурласан ерөнхий хүний эрхийн боловсролын багц - *Эрхээ бодит болгоё: Жендэрийн ойлголт ухамсарыг дээшлүүлэх сургалт*

Хоёрдугаар хэсэгт нь хүчирхийлэлд өртөхгүй байх эмэгтэйчүүдийн эрхтэй холбогдох хууль болон хүний эрхийн хэм хэмжээг үзүүлсэн гарын авлага - *Эрхээ бодит болгоё: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд хандах улс орны үүрэг.*

Үүнд гэр бүлийн хүчирхийлэл, олон нийт дэх хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар эрүүгийн хуулинд тусгагдсан байдал, хүчирхийллээс амьд үлдэгсэд, хүчирхийллийн золиос болсон эмэгтэйчүүдэд зориулсан үйлчилгээ зэргийг багтаасан болно.

Эрхийг эдлүүлэх нь - Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажил өрнүүлэх нь гэсэн гурван цуврал нь өмгөөлөгчдөд иргэний болон эрүүгийн шүүхэд хууль зүйн өмгөөлөл үзүүлэх, кампанит ажил өрнүүлэх, лобби хийх гэх мэт бодит байдал дээр тулгуурласан аргууд, мөн иргэний нийгмийн байгууллага, эрх баригчид болон засгийн газар хоорондын байгууллагуудад хэрхэн яаж хандах тухай өгүүлсэн болно.

Түүнчлэн *Эмнести Интернэшнлийн кампанит ажлын гарын авлага* нь кампанит ажлыг хэрхэн өрнүүлэх талаар илүү нарийн мэдээллийг өгүүлсэн тул та мөн хэрэглэж болно. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох Эмнести Интернэшнлийн кампанит ажлыг өрнүүлэх : *»Энэ бүхэн бидний гарт байна: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооё«* хэмээх илтгэлийг та Үзэж болно. Мөн <http://web.amnesty.org/actforwomen> цахим хаягаар орж үзвэл эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар өгүүлсэн чухал мэдээллээр арвин.

2. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажил

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь эцэс төгсгөлгүй бөгөөд хамгийн ээдрээтэй, хамгийн нуугдмал даад оршдог хүний эрхийн зөрчил.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь ерөнхийдөө мэдээлэгддэггүй өнгөрдөг. Энэ хүчирхийлэл бүс нутаг, шашин шүтлэг, соёл заншил, эдийн засгийн хил хязгааргүйгээр эмэгтэйчүүдийг бүх давхрага, арьс өнгө, угсаа гарал, нас, шашин, итгэл бишрэл, бэлгийн чиг хандлага, тэр ч байтугай хөгжлийн бэрхшээлтэйг нь ч ялгахгүйгээр оршиж байна.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд дэлхий даяархи эмэгтэйчүүд дэлхий нийтээрээ өөр өөрсдийн тодорхой онцлог байдлаас хамааран өртөж байна.

Олон улс оронд үнэт зүйл, итгэл Үнэмшлээсээ болж эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг «төрөлхийн» буюу «жирийн үзэгдэл» мэт болгож бүр хүлээн зөвшөөрөгдсөн зүйл болгосон байна.

Эмнести Интернэшнлийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажил 2004 оны 3-р сарын 5-наас эхлэн өрнөсөн бөгөөд эн түүрүүнд гэр бүлийн болон зэвсэгт мөргөлдөөний үеийн хүчирхийлэл рүү чиглэж байна.

Бидний тавьж буй урт хугацааны зорилтууд нь:

1. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдийг ял зэмгүй өнгөрөөдөг хуулиудыг өөрчлөх

2. Зэвсэгт мөргөлдөөний үед болон мөргөлдөөний дараа эмэгтэйчүүдийг хамгаалах үр дүнтэй хууль гаргаж, хэрэгжүүлэн хүчирхийлэл үйлдсэн цэргүүд болон цэргийн дарга нар нь ял зэмгүй өнгөрөх явдлыг таслан зогсоох.

3. Тухайн улс орон дангаараа эсхүл бусадтай хамтран олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргээ биелүүлж, тайван цагт ч, зэвсэгт мөргөлдөөний үед ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж, шалган мөрдөж, шийтгэн, хохирлыг барагдуулах арга хэмжээ авах.

4. Иргэний нийгэм, орон нутгийн засаг захиргаанаас олон нийтийн дунд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулах

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажил нь урьд өмнөх кампанит ажлуудаас доорхи 4 зүйлд анхаарал хандуулж байгаагаараа ялгаатай юм. Үүнд:

- Энэ кампанит ажлын зорилго нь гэр бүл дэх болон мөргөлдөөний үе дэх хүчирхийлэл, хүчирхийллийн цаад үндсэн шалтгаан нь болж байдаг ялгаварлан гадуурхах байдлыг устгах бөгөөд бие хүнд чиглэсэн үйл ажиллагааг явуулахад оршино. Мөн энэ кампанит ажил нь төрийн хүлээх хариуцлагыг шаардаж, сануулаад зогсохгүй, хувь хүн, нийгмийг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагаанд биечлэн оролцохыг уриалах юм.

- Энэ кампанит ажлаараа эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, бусад бүлгүүдтэй хамтран ажиллахыг зорино.

- ЭИ-ийн секц болон бүтцүүдийг өөрсдийн орондоо судалгаа хийж кампанит ажлаа өөрийн орондоо тухайн зүйл рүүгээ чиглүүлэн ажиллахыг дэмжинэ. Орон нутаг, дэлхийн хэмжээнд хийж буй судалгаа, явуулж буй кампанит ажлын зөрүүг арилгах үүднээс секц, бүтцүүд олон улсын хэмжээнд хамтдаа кампанит ажил өрнүүлэх, судалгаа явуулах

- Энэ кампанит ажил нь стратегитайгаар лобби хийж, судалгаа явуулж, хэвлэл мэдээлэл, интернэт ашиглан идэвхитнүүдээр захидал бичүүлэх зэрэг кампанит ажлын олон арга хэрэгслүүдийг нэгтгэж байгаагаараа онцлог юм.

3. Заавал мөрдөх зүйл: Өөрчлөх арга хэрэгсэл

Хүний эрхийн хуулиудыг авч үзэхэд эмэгтэйчүүдийг хүчирхийллээс илүүтэйгээр хамгаалах шаардлагатай гэдгийг харуулдаг. Зарим орон улс төрийн хүсэл эрмэлзлэлгүйн улмаас эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах үндэсний хууль тогтоомжоос илүү үр дүн өгөх олон улсын гэрээ, бичиг баримтуудыг хөрвүүлэн авах тал дээр учир дутагдалтай байна. Мөн хууль хэрэгжүүлж буй этгээдүүдийн хооронд уялдаа алга байна. Гэвч эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах хууль гарч, мөрдөгдөх ёстой. Үнэн хэрэгтээ эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг үндэсний хууль тогтоомжийг бий болгох, батлах нь сүүлийн арван жилийн гол амжилтуудын нэг болж байгаа билээ.

Улс орнууд нь олон улсын хүний эрхийн хуулиар өргөн хүрээтэй хариуцлага үүрдэг. Үүнд эмэгтэйчүүдийн эрхийг «хүндэтгэх» (жишээлбэл, эмэгтэйчүүдийн хүний эрхийг зөрчиж байгаа этгээдэд төр засаг хариуцлага тооцох); эмэгтэйчүүдийн эрхийг «хамгаалах» (жишээлбэл, хувь хүн, албан байгууллага, пүүс компаниуд ялгаварлан гадуурхахгүй байхыг баталгаажуулах), мөн эмэгтэйчүүдийн эрхийг «хэрэгжүүлэх» дэмжих» (жишээлбэл, эмэгтэйчүүд эрхээ эдлэж байгааг батлах, эрхтэй гэдгийг нь мэдүүлэх, эрх зүйн туслаалцаа үзүүлэх гэх мэт)

Өнгөрсөн арван жилийн туршид төрийн бус этгээд, хувь хүн, нийгэм дэх бүлгүүдийн хоорондох хүний эрхийн зөрчилд улс орон хөндлөнгөөс оролцож өөрийн үүрэг хариуцлагаа анхаарах явдал өсөж байна. Улс орон төрийн бус этгээдийн үйлдсэн хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тал дээр алдаа гаргавал олон улсын өмнө тодорхой хариуцлага хүлээх ёстой.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхахыг устгах Хорооны 19-р Ерөнхий Зөвлөмжинд «Олон улсын эрх зүй, хүний эрхийн гэрээ, конвенцийн дагуу улс орнууд нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эсхүл тийм хэргийг мөрдөн шалгах, буруутай этгээдтэй хариуцлага тооцох,

хохирогчдод нөхөн төлбөр олгох үүргээ умартвал өөрөө хариуцлага хүлээх ёстой» гэж заасан байдаг.

Америк Дундын Хүний Эрхийн Шүүх «Велагус Родригус»-ийн хэргийг авч үзэхдээ 1989 онд улс төрийн зүтгэлтнүүдийг барьцаалан алан хядсан «үхлийн салаа» нэртэй зэвсэгт бүлэглэл нь Гондурас улсын зэвсэгт хүчинтэй шууд хамааралгүй ч Гондурас улс иргэд нь бие биенийхээ эрхийг зөрчиж буйг таслан зогсоож чадаагүй учир олон улсын эрх зүйн дагуу тус улс хариуцлага хүлээнэ гэж тогтоосон байна. Энэ нь заавал мөрдлөгө болгон ажиллах зүйлийн эрх зүйн үндсэн зарчим юм.

Заавал мөрдөх зүйлийн ерөнхий зарчим нь хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн аль аль нь тус улсын төлөөлөл болох бөгөөд эрхээ бодитоор хэрэгжүүлэхгүй байгаад тухайн улс хариуцлага хүлээхийг тодорхой болгож өгч байгаа хэрэг.

Заавал мөрдөх зүйл гэдэг нь улс орнууд хүний эрхийн зөрчил гарсныг мэдэнгүүтээ үүргээ биелүүлж зөрчлөөс урьдчилан сэргийлж, зогсоох буюу шийтгэх, хохирогчдыг нөхөн сэргээх асуудал дутмаг байгаагаа олж мэдэхийг хэлж байгаа юм.

Үндэсний засгийн газар нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл- эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх түүнчлэн зөрчил гарсны дараа хүчирхийлэл үйлдэгчдэд хуулийн хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.

Энэ нь засгийн газар хүчирхийллийн тохиолдлыг хүмүүжил сургалтаар, хуулиар болон хэмжигдэхүйц бодитоор бууруулах үүрэг хүлээсэн гэсэн үг юм. Үүнд тухайлбал, эмэгтэйчүүд хүчиндүүлсэн тухайн газрын гэрэлтүүлгийг сайжруулах эсвэл эмэгтэйчүүдийн эрхийн тухай мэдээллээр хангах зэрэг орно.

Зарим улс орон олон улсын хүний эрхийн хуулийн дагуу хүлээх өөрсдийн үүрэг хариуцлагыг хязгаарлан, буруу нэвтрүүлдэг. Үнэндээ, төрийн болон төрийн бус этгээдийн аль аль нь сэрэмжлүүлэх, шалган

мөрдүүлэх, шийтгүүлэхээс ангид байх ёсгүй. Энэ нь тухайн улс орон хувь хүний үйлдэх хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэргийг мөрдөх, ял хүлээлгэх үүрэгтэй гэсэн үг.

Энэ нь нөхөр, хамтран амьдрагч, хамт ажиллагсад, гэр бүлийн гишүүд, хөрш, бусад хувь хүмүүс болон төрийн бус этгээдээр үйлдэгдсэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд гол түлхэц болдог. Энэ нь тухайн улс орон гэр бүл дотор хамгийн элбэг гардаг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, зэвсэгт мөргөлдөөний үед төрийн болон төрийн бус этгээдийн үйлдсэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд тйр хариуцлага хүлээнэ гэсэн үг юм.

Эдгээр үүрэг, хариуцлага нь заавал мөрдөх зүйлийн тавьсан шаардлагын дагуу хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх, дэмжих зэрэг бөгөөд үүнийг НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, бүс нутгийн хүний эрхийн байгууллагууд улс орнуудыг хүний эрхийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буйд хяналт тавих, амлалтаа хэр хэрэгжүүлж буйд хяналт тавихдаа хэрэглэдэг.

Танай засгийн газар бүх иргэдийнхээ хүний эрхийг хамгаалдаг уу?

о Зайлшгүй мөрдөх зүйл нь зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хэргийг мөрдөн шалгах, ял оноох зэрэг үр нөлөө бүхий алхамуудыг багтаана. Энэ нь мөн хохирогчдод тохирсон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хохиролыг барагдуулах, хариуцлага тооцох, яллах зэрэг нь ямар ч тохиолдолд ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг батална гэсэн үг юм.

Улс орон үндэстний болон олон улсын аль ч түвшинд дээрхи зөрчлийг сэрэмжлүүлж чадаагүйгээс болж алдаа гаргавал төр хохирогчдыг хохиролгүй болгож, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулж, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцох ёстой.

Үе шаттайгаар хэрэгжүүлэх дараах гарын авлагыг танд засгийн газартайгаа олон улсын эрх зүйгээр хариуцлага тооцон, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажлын талаарх заавал мөрдлөгө болгон ажиллах зүйлийг ерөнхий арга болгон ашиглахад зориулан гаргалаа.

Заавал мөрдлөх зүйлийг жишиг болгон хэрэглэснээр:

- Кампанит ажилд оролцогчдод хүний эрхийн үндэс суурь болсон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход төрийн болон төрийн бус этгээдийн үйлдэж буй хүчирхийллийн өмнө улс орны үүрэг хариуцлагыг уриалах арга замыг олно.



- Төрийн бус хүчирхийлэл үйлдэгчдээс урьдчилан сэргийлэх болон тэдэнд хариуцлага тооцох өргөн цар хүрээтэй өөрчлөлтийг бий болгох бодит суурь үндэслэлийг гаргаж ирнэ

- Орон нутгийн эрх баригч, улс төрч, болон бусад лидерүүдтэй ярилцсаны үндсэн дээр тэдэнд энэ асуудлаар ойлголт өгч, орон нутгийн тившинд уриалга гаргаж болно.

Заавал мөрдөх зүйлийг кампанит ажлын арга хэрэгсэл болгох нь

Үе шаттайгаар хэрэгжүүлэх энэхүү гарын авлага зорилтоо зөв тодорхойлж, оновчтой тактикуудыг хэрэглэн, зорилгодоо хүрэхэд тань туслана. Та кампанит ажилдаа дараахи зүйлийг хийх ёстой. Үүнд:

- Асуудлаа тодорхойл
- Цаад учир шалтгааныг гаргаж ир
- Зорилгоо гарга
- Кампанит ажлаараа шийдвэрлэх асуудлыг тодорхойл
- Зорилтот бүлэг болон арга замаа тодорхойл
- Кампанит ажлынхаа үйл ажиллагааг төлөвлө
- Үнэлгээ болон тайлан гарга

Нэгдүгээр шат:
Өөрийн улс орныхоо нөхцөл байдлыг тодорхойлох.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл бол хүний эрхийн зөрчлүүд доторхи хамгийн ээдрээтэй бөгөөд нуугдмал нь юм. Энэ нь бараг дэлхий даяар мэдээлэгдэхгүй, хил хязгааргүйгээр оршин тогтнож байна.

Хүчирхийлэл гэдэг нь ялгаварлан гадуурхах, эмэгтэйчүүдийг эрчүүдтэй ижил тэгшээр үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэхэд нь саад болохыг хэлнэ.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн хэрэгт ял зэм өгөхгүй өнгөрөх нь маш их байдаг бөгөөд Засгийн газар хүчирхийллээс ангид байх орчин нөхцлийг бүрдүүлэх тал дээр доголдолтой байна. Дээр өгүүлсэнчлэн, улс орон ард түмнээ хүчирхийллээс хамгаалах үүрэгтэй.

Хүчирхийлэл төрийн төлөөлөл болох цагдаагийн ажилтан, цэргийн албан хаагч эсвэл хувь хүмүүс

болон бүлэг хүмүүсээр олон нийтийн газар эсхүл хувийн, тухайлбал гэр бүл дотор үйлдэгддэг нь үнэн.

Хүний эрхийн асуудалд улс орны хүлээх үүрэг нь олон улсын хуульд заагдсан байдаг хэдий ч бүх улс орон энэ үүргээ бүрэн дүүрэн биелүүлдэггүй байна.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх мэдэл, үүрэг роль нь уламжлалт соёлоор хүлээн зөвшөөрөгдсөн мэт байдаг бөгөөд олон улс оронд хүчирхийллээс эмэгтэйчүүдийг бүрэн хамгаалах хууль байдаггүй байна. Тухайлбал зарим улс оронд нөхөр нь эхнэрээ хүчиндсэн тохиолдолд хориглосон хууль байдаггүй бол Ардчилсан Конго улсад цэргүүд нь нэгэн эмэгтэйг хүчиндсэн хэрэгт цэргийн болон иргэний удирдагчид мэдэгдэл гаргахдаа тэр эмэгтэйг шууд буруутгаж байсан байна.

»Жендэрийн доголдол« гэдэг нь эмэгтэйчүүдийг онцгойлон авч үзээгүйгээс болж зарим тохиолдолд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг нийгмээрээ жирийн үзэгдэл мэт хүлээн зөвшөөрч гэмт хэрэг гэж үзэхгүй үүнд анхаарлаа хандуулахгүй байгааг хэлнэ.

Үндэсний хууль тогтоомжинд өөрчлөлт оруулах талаар лобби хийхдээ өөрийн орны хууль тогтоомж нь олон улсын хүний эрхийн чиг хандлага, олон улсын хүмүүнлэгийн хуультай хэрхэн нийцэж буй тал дээр учир дутагдалтай байгааг олон нийтэд мэдээлж болно.

Үндэсний хууль тогтоомжид дүгнэлт хийх:

Та өөрийн орны эрх зүйн орчинд дүгнэлт хийж тодорхойлох хэрэгтэй. Тухайлбал:

1.Танай оронд хүний эрхийн ямар гол чиг хандлагууд одоогоор батлагдаад байна вэ? Жендэрээр ялгаварлан гадуурхсан юм уу хүчирхийлэлд хариуцаага тооцохгүй өнгөрдөг жендэрийн тэгш бус байдлыг хадгалсан ямар хууль байдаг вэ? / Жишээлбэл: зан заншлууд нь байнга эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхдаг/.

2. Ялгаварлан гадуурхах нь гэр бүл салах, хөрөнгө өвлөх, эд хөрөнгөтэй байх зэргээр эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарлаж, тэднийг хүчирхийлэлд хүргэж байна уу?.

3. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж буй этгээдэд ял тулгахад эрх баригчид ямар хуулиуд батлан гаргах шаардлагатай байна вэ? Тухайлбал: Гэрлэгсдийн дундах хүчингийн гэмт хэргийг агуулсан хууль гаргах (жишээлбэл Филиппинид эмэгтэйчүүдийн бүлгээс явуулсан нийллийн ажлын дараа 1997 онд эрүүгийн шинэ хуулиндаа аман секс болон сексээр эрүү шүүлт тулгах хүчингийн хэргийг нарийн тодорхойлсон)

4. Үндэсний зэвсэгт хүчний эсрэг гаргасан санал гомдлыг шалган мөрдөх бие даасан нөлөө бүхий механизм байдаг уу?

6. Эмэгтэйчүүдийг хүчирхийллээс дүрвэн орогноход нь тус болохуйц ямар хамгаалалт байдаг вэ? (Жишээлбэл 1993 онд Канадын засгийн газар жендэрт суурилсан хавчлагын улмаас нийтийг хамарсан олон тооны улс төрийн орогнолын шалтгаанаас санаа авч шинэ удирдамжийг гаргасан.

7. Хүчирхийллээс амьд үлдэгсэд ямар ямар эмнэлгийн үйлчилгээ, хамгаалалт, нөхөн олговор зэргийг авдаг вэ? Эдгээр нь тэдний нийгэм, эдийн засаг, иргэншлийн статусыг үл тоомсорлосон хандлагатай байдаг уу?

8. Эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах ямар алхмууд авагдсан бэ? (Жишээ нь эмэгтэйчүүд хүчирхийллээс зугтаж аюулгүй орон байраар хангагддаг уу? Тэдэнд болон хүүхдүүдэд нь зориулсан хоргодох газар байдаг уу?)

Та энэ хууль зүйн дүн шинжилгээг бусад эмэгтэйчүүдийн болон хүний эрхийн байгууллагуудтай хамтран хийж болно. Эмэгтэйчүүдийн байгууллагууд, дэмжигч бүлгүүд, зөвлөгөө өгөх төвүүд болон бусад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар ажилладаг байгууллагуудтай холбогдож ямар төрлийн судалгаанууд аль хэдийнээ гарчихаад байгааг олж мэдэх хэрэгтэй. Та мэдээллээ гүйцэд олж авч чадаагүй бол ийм төрлийн бүлгүүдтэй хамтын ажиллагаа тогтоож, олж авч болно.

Та өөрийн орны хууль тогтоох байгууллагаас гаргасан холбогдох хуулиудын нэг хувийг өөртөө авах хэрэгтэй. Үүнийг яамны цахим хуудас болон номын сангаас онлайнаар авах боломжтой.

НҮБ-ын Ерөнхий Асамблейн гаргасан болон бусад олон улсын чуулганаас гаргасан тунхаглал баримт бичгүүд байдаг бөгөөд эдгээр нь хүний эрхийн асуудал болсон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд чиглэсэн байдаг. Үүнд Эмэгтэйчүүдийн Эсрэг Хүчирхийллийг Устгах Нэгдсэн Үндэстний Тунхаглал, Бээжингийн Тунхаг бичиг болон Ерөнхий Ассамблейн Тусгай Чуулганаас 2000 онд гаргасан баримт бичиг орно (Бээжин + 5).

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хүнд хэлбэрүүдийг /тухайлбал алах, эрүү шүүлт үзүүлэх болон гэмтээх, хүчиндэх болон бусад хүйсийн хүчирхийлэл мөн бусад ялгаварлан гадуурхалаас үүдэлтэй хүчирхийлэл/-үүдийг хуулиар хориглох нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд үүнийг олон улсын хуулийн тогтсон заалтуудад уялдуулж өгөх шаардлагатай.

Улс орон олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орохдоо олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу дотоодын хууль тогтоомжуудыг батлан гаргахад улс орны оролцоог бий болгох.

Олон улсын хүний эрхийн хууль нь бүх улс орнуудыг өөрийн орны хүний эрхийн хуулиа гаргах эрхээр хангаж өгдөг. Энэ нь бусад хүмүүсийн эрхэд нөлөөлж буй хувь хүмүүсийн хэрэгт улс орон оролцох үүрэг хариуцлагыг багтаадаг.

Бүс нутгийн хүний эрхийн чиг хандлага

Бүс нутгийн хүний эрхийн чиг хандлага нь эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хэрэгжүүлэхийг улс орнуудаас шаарддаг.

Гол холбогдох чиг хандлагууд нь: Европийн хүний эрхийн Конвенц, Африкийн Хүний болон Ард түмний Эрхийн Тунхаглал, мөн үүний Африк дахь эмэгтэйчүүдийн эрхийн протокол, Америкийн хүний эрхийн конвенц юм. Америк хоорондын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг сэргийлэх, шийтгэх, зогсоох конвенц эсрэг хүчирхийлэлд тусгайлан чиглэсэн цорын ганц бүс нутгийн нарийвчилсан конвенц юм.

Хоёрдугаар шат
Гадаад болон дотоод нөхцөл байдлаа
тодорхойлох

Бидний дараагийн алхам бол өрнүүлэх кампанит ажилдаа дүгнэлт хийх. Кампанит ажлын нөхцөл байдал, зорилтыг сонгох арга замд нөлөөлөхүйц ямар ямар хүчин зүйлс байна вэ? Танай оронд эдийн засаг, нийгэм, соёл, улс төр болон хууль зүйн хандлагууд нь эмэгтэйчүүд, хүний эрх, хүчирхийллийн бодит байдалтай хир уялдаж байгааг та анхааран үзэх хэрэгтэй.

Эдгээр хүчин зүйлс нь танай орны одоогийн нөхцөл байдлыг сайжруулах таны бодож байгаа хамгийн том нөлөөлөл болж чадна; та ямар бодит өөрчлөлт хийж чадна гэдэгтээ итгэлтэй байна; та ямар шинийг санаачлагч болон шийдвэр гаргагчидтай хамтрах; болон танай кампанит ажлын «хэлбэр» ямар вэ?

Та аль ч кампанит ажлынхаа гадаад нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ давуу тал, сул тал, боломж, аюул заналхийллээр товч анализ хийж,

байгуулагынхаа зохион байгуулалт болон нөөц чадавхийг уялдуулан тогтоож болно.

Та кампанит ажлынхаа дараагийн хэсэг рүү орохдоо өөрийн сайн хийж байгаа болон давуу тал руугаа чиглүүлэх хэрэгтэй. Энэ нь танай орон эмэгтэйчүүдийн эрхийн асуудал дээр бусад байгууллагуудтай ойр ажиллахад зорилтоо тодорхойлох болон бие даасан үйл ажиллагаа явуулахын өмнөх чухал алхам болох юм.

Эмэгтэйчүүдийн байгууллага гол үүрэгтэй байх нь

Хэрэв танай байгууллага хүний эрхийн ажилд уламжлалт байдлаар ханддаг бол, эмэгтэйчүүдийн эрхийн кампанит ажил, хүчирхийллийн талаар олон жилийн туршлагатай, сайн зохион байгуулалттай олон улсын сүлжээ байгаа гэдгийг та санах хэрэгтэй.

Танай кампанит ажлын дараагийн алхам бол эмэгтэйчүүдийн байгууллагуудтай холбогдож, тэд юу хийж байгаа, тэдэнд яаж тусалж чадах вэ гэдэг юм. Олон оронд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн асуудал мэт байдаг. Иймээс хүний эрхийн байгууллагууд эмэгтэйчүүдийн байгууллагад



эхэлж хандаж асуудлыг гаргаж тавих нь тэдэнд хүндрэлтэй байдаг байж болох юм.

Туршлага сайтай эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нь энэ асуудлыг дэмжиж, хүлээн зөвшөөрүүлэхэд туслах хэрэгтэй.

Жишээлбэл, Английн ЭИ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх төслийг явуулахынхаа өмнө, орон нутгийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнтэй зөвлөлдөж, энэ асуудлаар судалгаа, үйл ажиллагаа явуулах туршлагатай болж авсан байна.

Эрчүүдийн оролцоог хангах

Түүнчлэн та кампанит ажлаараа эрчүүдийг яаж татан оролцуулахыг тооцох хэрэгтэй. Эрчүүд гадаад дотоод хүрээлийн аль аль нь болдог. ЭИ шиг эрэгтэй эмэгтэй гишүүдтэй ийм байгууллага эрчүүдийг энэ зүйл рүү татан оролцуулахад тохиромжтой.

Эрчүүдтэй хамтран ажилласнаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход тэд өмгөөлөгч хамгаалагчийн байр суурьтайгаар оролцоно гэдгээр тэднийг урамшуулж байх хэрэгтэй. Зарим эрчүүд энэ асуудал дээр идэвхи чармайлттай ханддаг бол ихэнхи нь энэ асуудалд хөндий хойрго ханддаг.

Тэд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тал дээр маш хязгаарлагдмал ухамсартай, яаж нөлөөлөх тал дээр ч явцуу бодолтой байдаг. Та үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг гаргахдаа энэ тухай бодолцож тусгах хэрэгтэй.

Бусад холбоос

Чадамж /оюуны/-тай холбоотнууд: эмнэлгийн ажилтан, хуульч, багш, халамжийн байгуулагынхан, цагдаагийн албан хаагчид, үйлдвэрчний эвлэл болон сэтгүүлчид.

Нэмж тодорхойлоход, та дээрх бүлгүүдээс хэн нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын эсрэг байх вэ гэдгийг тогтоох хэрэгтэй. Таны эсрэг ямар маргааныг ямар тактиктаар ашиглаж болох вэ гэдгийг та кампанит ажлынхаа нэг хэсэгт урьдчилан тооцоолж оруулах хэрэгтэй.



Загреб-д Хорватын ЭИ-ийн ЭЭХТЗ кампанит ажлын үеэр.
2004 оны 3-р сар

Гуравдугаар шат: Зорилтоо тогтоо

Та зорилт бүхнээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг зогсоох ерөнхий зорилгод хүрэх нэг алхмын ойр байхаар гаргаж өгөх хэрэгтэй.

Та зорилгодоо хүрэхийн тулд зайлшгүй мөрдлөгө болгон ажиллах зүйлийн агуулгыг зорилтууддаа тусгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, эдгээр зорилтууд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг багасгах танай орны Засгийн газрын хүлээх үүрэг хариуцлагатай уялдана гэсэн үг юм.

Зорилтууд нь SMART-аар хэмжигдэхүйц байх ёстой:


- Specific-онцлог
- Measurable - хэмжигдэхүйц
- Achievable - зорилгодоо хүрэхүйц
- Relevant - хамааралтай байх
- Time bound - цаг хугацаатай байх

Энэ нь таныг юунд зориод байгааг чинь тодорхой болгож, үйл ажиллагаагаа төлөвлөхөд чинь туслах юм. Ингэснээр энэ нь таны хүсэн хүлээсэн үр дүнг авчирч үнэлгээгээ хялбархан гаргахад тань нэмэр болно.

Та бүхэн кампанит ажлаа сайжруулахын тулд дараахи гарын авлагуудыг ашиглаж болно: »Стратегитай кампанит ажлын эргэлт«,»Асуудал болон шийдлийн хэлхээ«. *Эмнэсти Интернэшнлийн кампанит ажлын гарын авлага*-ын 25-р хуудаснаа »Стратеги кампанит ажлын эргэлт«-ийг хэрхэн сайжруулах тухай нарийвчлан гаргасан байгаа.

Тус гарын авлагын 13 болон 24-28 дугаар хуудсанд үүний талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл байгаа. »Асуудал болон шийдлийн хэлхээ« нь танд нөхцөл байдлыг дүгнэх ба танд зорьж буй гол асуудлаа тодорхойлоход туслана. Үүнийг та бүлгээр юм уу бусад байгууллагуудтай ажиллахдаа ашиглаж болох юм.

Стратегийг сайжруулах



Бидний төлөвлөгөө хүрч болохуйц, бодит уу? Бидэнд хангалттай нөөц боломж байна уу? (цаг хугацаа? мөнгө? хүмүүс?)
Бидэнд зорилтоо өөрчлөх шаардлага байна уу?

Асуудлын хэлхээс



Та, жишээлбэл, үүний тусламжтайгаар танай орон эмэгтэйчүүдийг хамгаалах хууль дутагдалтай байгаа эсэхийг тогтоож болно.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн хүний эрхийн талаархи нийтийг хамарсан хэлэлцүүлэг нь гол шалтгаан болж, нь гэр бүл дэх хүчирхийллийг хүлцэн тэвчих нь хоёр дахь шалтгаан болж байна гэж та үзэж болно.

Шийдлийн хэлхээс



Таны туйлын зорилго болох ЭБХЯГТКонвенцийг соёрхон батлуулах хэрэгжилтийг хангуулах болон тогтсон уламжлалыг өөрчлөн, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар нийтээрээ хэлэлцэх асуудлыг гаргаж, олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх зорилго тавих хэрэгтэй.

Энэ нь ЭБХЯГТКонвенцид нэгдэн ороход тус дөхөм болох юм.

Доорхи жишээнүүдийн ихэнхи нь ЭИ-ийн ОУНБДН-ын газар болон ЭИ-ийн секц бүтцүүдийн тавьсан жинхэнэ зорилтууд бөгөөд та эдгээрээс

өөрийн орны хууль зүйн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр сонгон авч хэрэглэж болно.

Загвар А: Хууль зүйн өөрчлөлт

Дүгнэлтээс үзэхэд танай засгийн газар олон улсын жишиг хэмжээг өөрийн хууль зүйн тогтолцоондоо авч баяжуулаагүй учраас эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах эрх зүйн хамгаалалт муу байгаа нь харагдаж байна. Иймээс та кампанит ажлынхаа зорилтыг энэ зүйл рүү чиглүүлэх боломжтой юм.

Зорилтууд нь ерөнхийдөө дараахи зүйлд чиглэнэ: ЭБХЯГТК-д нэгдэх - нарийвчлах - гарч буй хэвшил болсон хуулиудыг өөрчлөх.

Энэ нь таны бусад байгууллагуудтай хийсэн уулзалт ярилцлага, судалгаатай хамааралтай бөгөөд, хэрэгцээ болон амжилт гаргах боломжийг харуулах юм. Зорилтууд нь эмэгтэйчүүдийн эрхийг зөрчсөн, ялгаварлан гадуурхсан хуулиуд болон жендэрт суурилсан хүчирхийлэлд хариуцлага тооцохыг уриалах юм.

Танай Засгийн газар НҮБ болон засгийн газар хоорондын байгуулагаар хүлээн зөвшөөрөгдсөн жишиг хэм хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Таны сонгож болон тохируулж болох стандартын жишээ:

- Танай орон ЭБХЯГТК болон тусгай протоколд нэгдэн ороогүй бол нэгдэж орох

- Танай орон ЭБХЯГТК-т байгаа аливаа тайлбарыг зөрчихгүй байх. (жишээлбэл заншлын хуультай холбоотой нийтлэлийг хязгаарлахгүй байх гэх мэт)

- Хэрэв танай засгийн газар ЭБХЯГТК-г баталсан бол хуулиудаа ЭБХЯГТК-той эн зэрэгцэхүйц болгох ёстой. Ингэснээр хуулинд ЭБХЯГТК-ын хүний эрхийн зөрчлийг нэгтгэн оруулж өгөх ёстой юм.

- Танай улс гэрээнд хяналт тавих үүрэг бүхий тодорхой байгууллагад илтгэлээ өргөн барих ёстой. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх талаар өөрийн орны явуулж буй ажлын талаар ЭБХЯГТ конвенцийн хороонд

сүүдэр илтгэлийг бусад байгууллагуудтай нэгдэн сүүдэр илтгэлийг бэлтгэн өгдөг.

- Танай орон Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд нэгдэн ороогүй бол нэгдэн орох

- Танай орон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой дотоодын эрүүгийн хуулийн загвар болох олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм журам болон гэмт хэргийн тодорхойлолтыг ашиглах.

- Эмэгтэйчүүдийг хүчирхийлээс хамгаалах шинэ хуулийг гаргахад засгийн газарт хэрэгцээт мэдээлэл гаргаж өгөх. Жишээлбэл гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж үзэх шинэ хууль хэрэгцээтэй байгаа наад зах нь 78-н орон байдаг. Зарим орон гэрлэгсдийн дундах хүчинг гэмт хэрэг гэж үздэг хуульгүй байсаар байна.

- Эмэгтэйчүүдийг илтээр ялгаварласан буюу эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд ял оноохгүй өнгөрөхийг зөвшөөрсөн хуулиудыг халах нийтийг хамарсан кампанит ажил өрнүүлэх. Эдгээр хуулиуд нь одоогийн байдлаар 54 оронд байна.

- Албадан гэрлэлт, эхнэр нь хөрөнгө өвлөх, гэр бүл бологсодын хоорондох хүчин, насанд хүрэгчдийн дундах гэрлэлтээс гадуурхи бэлгийн харилцаа зэрэгтэй холбоотой хуулин дахь ялгаварлан гадуурхсан заалтуудыг халах.

- Засгийн газар гэр бүлийн хүчирхийллийн хууль тогтоомжийн үр дүн нөлөөлөлд дүгнэлт хийж эмэгтэйчүүдийн байгууллагуудтай хамтран үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсронгуй болгох.

Загвар В: Бодлого практикийг өөрчлөх.

Түүнчлэн та хуулинд өөрчлөлт шаардагддаггүй албан ёсны бодлого болон туршилтыг өөрчлөхийг кампанит ажлынхаа зорилгонд оруулж болно. Эдгээр нь шүүхийн тогтолцоо, цагдаа, цэргийн болон бусад үндэсний тогтолцоонд тусгагдаж болно.

Авч хэрэглэж болох жишээ:

- Зэвсэгт мөргөлдөөний үед эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үйлдсэн 2-оос доошгүй хүчирхийлэгчид та хариуцлага оногдуулахыг тогтоо. Жишээлбэл: террористуудад эзлэгдээд байгаа Ирак, Алжир, Колумб, Израйл.

- Хууль сахиулах үйл ажиллагаан дээр 2-оос доошгүй дэмжиж болохуйц зүйл санаачлан хийх.

- Өөрийн орны хүчирхийллийн хохирогч болсон хүн бүрийг эмнэлэгийн тусгай тусламжаар хангах.

- Өөрийн орны бүх цагдаа болон хамгаалалтын албаны ажилтнуудад хүйсийн мэдрэмжтэй сургалтууд явуулах.

Бүх хохирогчдод тэдний онцлогт тохируулан эмчилгээ үйлчилгээ, нөхөн сэргээх болон хохиролгүй болгох бүх үйлчилгээг явуулах.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь даяарчлагдмал болж байгаа бөгөөд олон эмэгтэйчүүд өөрсдийн тодорхой үзэл бодол онцлогоос шалтгаалан хүчирхийллийн янз бүрийн хэлбэрүүдэд өртсөөр байна. Эмэгтэйчүүд нь арьс өнгө, угсаа, соёл, хэл, бэлгийн чиг хандлага, ядуурал, эрүүл мэндээрээ ялгаварлан гадуурхагдаж байна.

Загвар С: Нийтийн хэлэлцүүлгийг өдөөх.

Улс орнууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх болон эмэгтэйчүүдийн хүний эрх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар ард нийтээрээ хэлэлцэх төвшин нь хоорондоо харилцан адилгүй байдаг.

Бүх улс орнууд болон зан заншил нь жендэрт сууриасан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн талаар ойлголтын төвшин, ард нийтийн хэлэлцүүлгээс гарах ач тус нь нэгдмэл юм.

Энэ хэлэлцүүлгийг өрнүүлснээр хуулийг бодит болгохыг зорьсон кампанит ажлын уур амьсгалыг бий болгох юм. Зарим оронд ард нийтийн ухамсрыг дээшлүүлэх ажил нь хууль зүй болон нийгмийг өөрчлөхөд зайлшгүй хэрэгцээтэй байна.

Та 1-рт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд ял шийтгэл оноохгүй өнгөрөх уламжлалыг халахыг зорих хэрэгтэй. Танай орны хувьд ЭЭХ-ийн талаар ард нийтийн ойлголт ухамсрыг дээшлүүлэх ажилд зорилгоо хандуулвал бодитой болох боломжтой юм.

Таны авч хэрэглэж болох жишээ болон арга замууд:

- ЭЭХ-ийг олон нийтийн хэлэлцэх асуудал болгох: Жендрээр ялгаварлан гадуурхах нь эмэгтэйчүүдийн эрхийг хэрхэн үгүйсгэж буйг харуулсан хүний эрхийн боловсролын сургалтуудыг танай орны шийдвэр гаргах түвшнийхэн, жишээлбэл: шүүгчид, цагдаа, цэргийнхэн, багш нарын дунд явуулж нөлөөллийн нэг арга болгож болох юм.

- Хүрээлэн буй хүчирхийлэл, хор нөлөөг өөрчлөхөд олон нийтийн ойлголт ухамсрыг дээшлүүлэх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд соёл заншил болон нийгэмтэй холбоотойгоор шийтгэл үзүүлдэггүй явдлыг хэвлэл мэдээлэл, боловсрол, эвсэл холбоодоор дамжуулан шаардах нэг арга байж болно.

Загвар Д. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл дээр ажиллах өөрийн байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх.

Та эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл дээр ажиллахдаа өөрийн байгууллагынхаа чадавхийг сайжруулах зорилтоо тодорхойлох хэрэгтэй. Жишээлбэл: ЭИ-ийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажлын явагдаж буй нэг л зүйлээр чадавхи тодорхойлогдоно.

Хүний эрхийн боловсрол олгох сургалтын материал нь тус гарын авлагад багтсан бөгөөд ээдрээтэй асуудалд тань туслах зорилготой.

Та байгууллага, ялангуяа, эмэгтэйчүүдийн байгууллага төдийгүй бусад хүний эрхийн байгууллага, шашны удирдагчид, нийгмийн хөдөлгөөн, хөгжлийн төлөө болон хүмүүнлэгийн байгууллагуудтай холбон өгч цар хүрээгээ тэлэх хэрэгтэй.

Таны авч хэрэглэж болох жишээ болон зорилтууд:

- Хүний эрхийн боловсролын сургалтыг гол хүний эрхийн зүтгэлтнүүд болох гүйцэтгэх товчооны ажилтан, гишүүд, сайн дурынхны дунд явуулж тэдэнд жендерийн тухай ойлголт олгох.

- Гүйцэтгэх товчоо байгууллагынхаа хүний эрхийн ажлын салшгүй чухал хэсэг болох жендэрийн чиг хандлагын тал дээр ур чадвараа сайжруулах. Жишээлбэл: өөрийн орны эмэгтэйчүүдийн талаарх статистик мэдээлэл цуглуулж, таны ажиллаж буй хэргүүд дундаас жендэрээс үүдэлтэй гэмт хэргийг шалган үзэх.

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн чиглэлээр ажилдаг 3-аас доошгүй байгууллагатай нэгдэн холбоо байгуулж, өөрсдийн байр сууриа солилцож хамтран мэдээ тайлан гаргаж байхаар тогтох хэрэгтэй.



2003 оны 3-р сард мянга мянган эмэгтэйчүүд лесби нарын цуглаанд нэгдсэн байна. Дэлхий даяар эмэгтэйчүүд бэлгийн чиг хандлагын хувьд хараат байх явдал өргөнөөр тархаж багаатай холбоотойгоор эрхээ хамгаалан тэмцэж байгаа юм.

Дөрөвдүгээр шат: Шийдвэрлэх аргыг тогтоох

Шийдвэрлэх арга гэдэг бол таны тавьсан зорилт яаж өөрчлөгдөх вэ? юу болох вэ? үүнийг хэн хийх вэ? гэдгийг тогтоох арга хэрэгсэл юм. Энэ нь танай нэг кампанит ажлын үйл ажиллагаанаас эхлээд таны хүрэх зорилт хүртлэх эрэмбэ дараалал бүхий арга замыг танд гаргаж өгөх юм.

Кампанит ажил гэдэг бол үр дүн, шатлалт алхамууд, үйл ажиллагааг давхцуулалгүй ажлаа төлөвлөх юм. Та ямар ч үед үйл ажиллагааг давхцуулалгүй дараагийн ажлаа эхлэхээс нэг алхмын өмнө ажлаа төлөвлөдөг байх хэрэгтэй. Ямар үйл ажиллагаа нь нэгдүгээрт тавигдаж бусдыгаа араасаа дагуулах амжилт боломж авчрах вэ гэдгийг урьдчилан тооцоолж байх хэрэгтэй. Кампанит ажилд оролцож буй идэвхитэй гишүүдийн сонирхолыг татах талаар бас бүтээлчээр бод.

Төрийн бус байгууллагууд нь өөрчлөлтөнд нөлөөлж чадах боловч тэд өөрсдийн биеэр бүхэл бүтэн хүн амд хүрч тэдэнд хууль зүйн өөрчлөлт, өргөн цар хүрээгээр боловсрол олгох болон бусад тусламжуудыг хүргэж чадахгүй.

Засгийн газар хүчтэй байвал та засгийн газрын сайдууд болон эрх баригчидтай хууль болон улс төрийн өөрчлөлт хийхэд заавал мөрдлөгө болгож

ажиллах зүйлийн өмнө хүдээх тэдний үүрэг хариуцлагыг ойлгуулах хэрэгтэй.

Харин засгийн газар сул дорой байвал та үүнийг өөрчлөх өөр арга замуудыг бодох хэрэгтэй.

Жишээлбэл: сул дорой засгийн газартай улс оронд байдаг олон улсын корпорацууд тухайн орондоо нөлөөлөл сайтай байдаг. Та тэдний дэмжлэгтэйгээр зарим өөрчлөлтийг хийхээр зорьж болох юм. Жишээ нь: нийгэмд суурилсан өмгөөлөл хамгааллын төсөл, ажилчдын ажлын нөхцөл байдлын талаарх жендэрийн мэдрэмж, ард иргэдийг олноор хамруулсан хүний эрхийн боловсрол болон санал асуулга явуулах гэх мэт. Танай орон ЭБХЯГТК-ыг дагаж мөрдөх тал дээр гаргасан алдааг илрүүлж болно. Үүнд хоёр л гол хуулийн хэсэг байдаг бөгөөд нэг нь жендэрийн тэгш байдлыг хэвшүүлэхэд чиглэсэн нөгөө нь жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлд ял оноох явдал юм. Нэмж хэлэхэд орон нутагт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл анхаарал татахуйц их байгаа боловч хүчирхийлэл үйлдэгчдэд оноосон ял байхгүй байна. Таны зорилтууд дараах байдлаар гарч болох юм.

- Засгийн газраа ЭБХЯГТК - д нэгдэн орохыг ятгах
- Жендэрийн тэгш байдлыг бий болгоход чиглэгдсэн хуулиудыг өөрчлөх эсвэл эдгээр хуулиудаа дахин хянаж алдааг засах.



Шийдвэрлэх арга зам дараахи байдлаар гарч болно.

1. Нөлөө үзүүлж чадахуйц шийдвэр гаргагчдын дунд нийтийг хамарсан ажил сургалтуудыг явуулах

2. Үндэсний хууль зүйн тогтолцооны талаар судалгаа явуулж олон улсын жишигт нийцэхгүй зүйлийг илрүүлэн, арилгаж, ард түмний амьдрал, хүний эрхэд тус нөлөө үзүүлэх.

3. Тус судалгааг өөрийн оронд тогтмол явагддаг хүний эрхийн чиг хандлагын дүгнэлт илтгэлтэй давхцуулан сүүдэр илтгэл болгон өргөн барих.

4. Хүний эрхийн зүтгэлтнүүдийг шийдвэр гаргагчдад уриалга, захидал, хүсэлтээ бичихэд туслах үүднээс мэдлэг чадварыг нь дээшлүүлэх.

5. Бусад байгууллага хүмүүстэй хамтран судалгааны талаархи мэдээллээ хэвлэл мэдээллээр явуулах.

6. Өөрийн байгууллагын цахим хуудсанд илтгэлээ нээлттэй өргөх бичгийн хамт тавих болон бусад үйл ажиллагааг явуулах.

7. Шийдвэр гаргагчидтай нүүр тулсан уулзалт хийж, биелэгдэхүйц зүйлсийг шаардан тҮҮнийгээ хүлээн зөвшөөрүүлэх.

8. Зохион байгуулсан үйл ажиллагааны ач холбогдол, үр нөлөөг нэгтгэн дүгнэж мониторинг хийх.

Кампанит ажил гэдэг бол нийгэмтэй харьцах харьцаа юм. Үүнд нэгдсэн тогтолцоо байгаад зогсохгүй, олон нийтэд хариу өгөх, төлөвлөөгүй үйл явдалд хариу өгөхдөө уян хатан байх хэрэгтэй.

Тавдугаар шат: Зорилтот бүлгээ тодорхойлох, тэдэнд хүрч ажиллах

Зорилтот бүлгээ тодорхойлох нь танд үр дүнд хүрэх аргаа сайжруулах, үр дүнд хүрэх аргынхаа эхний алхамд хүрэхийн аль алинд нь хэрэгтэй. Та өөрөөсөө дараах асуултуудыг асуу.

• Танд зорилгуудаа уриалан гаргаж тавихад хэн хүчтэй нөлөөлж, өөрчлөлт авчирч чадах вэ?

• Та тэдэнтэй шууд харьцаж чадах уу? Чадахгүй бол хэн чадах вэ?

• Тэдний хууль зүйн тогтолцооны болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи өнөөгийн ойлголт ямар байна вэ?

• Танд ямар ямар саад бэрхшээл, төөрөгдөл байна?

• Таны хийх үйл ажиллагаанд тэнднийг оролцуулахын тулд тэдэнд урам хайрлаж зоригжуулах ямар зүйл танд хэрэгтэй байна вэ?

Та бас шийдвэр гаргагчдад нөлөөлөх хүмүүсийг тогтоох хэрэгтэй. Жишээ нь:

- Иргэний үйлчилгээнийхэн
- Сэтгүүлч
- Олон улсын донорууд

- Шашин болон нийгмийн удирдагчид
- Идэвхитэн хувь хүмүүс

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг төгсгөл болгоход нөлөө үзүүлж чадахуйц улиг болоогүй оролцогчдыг зорихыг бод.

Тухайлбал: тамирчид, бизнесмэнүүд байж болно. Та ямар сувгаар эдгээр зорилгодоо хүрэх, оролцогчиддоо санал болгох зэргээ анхаарах хэрэгтэй.

Та зорьсон оролцогчдоо ямар хүмүүс байгааг мэдэнгүүтээ тэднийг юугаар өдөөх вэ гэдгээ тооцоолж хүсэн хүлээсэн өөрчлөлтөө тэднээр хийлгэхийн тулд тэдэнд урам зориг өгөх төлөвлөгөө гаргах хэрэгтэй. Тэд юмыг танаас өөр нүдээр харна гэдгийг сана. Та өөрийгөө тэдний оронд тавьж үзээд тэднийг өөрчлөлтөө хийхэд ямар асуудлууд, шахалт дарамт гарч ирж байгааг төсөөл.

Хэвлэл мэдээлэл болон захидал бичих кампанит ажлаар сонгогчдоос ирж буй ард нийтийн дарамт шахалт нь тухайн зүйлийг хэлэлцэх асуудал болгон гаргаж тавих хөшүүрэг болж чадах уу?

Нөлөөллийн зураг дахь нөлөөллийн диаграм болон нөлөөллийн холбоос нь таны зорьж буй оролцогчдоо тодорхойлоход танд тус дөхөм болох юм. Доор нэг жишээ өгөгдсөн байна.

Хялбарчилсан зураг.

Загвар: Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод тохирох эмнэлгийн тусламж үзүүлэх.



Нөлөөллийн гинж



Нөлөөллийн холбоос



Хялбаршуулсан хүснэгт

Оролцогчид	Таны тэднийг хамруулахаар хүсч буй үйл ажиллагаа	Та тэднээр үүнийг яаж хийлгэх вэ?
Үндэсний засгийн газар	Гэрлэгсдийн хоорондох хүчинг гэмт хэрэг гэж үзэх	Сонгогчдоос үзүүлэх шахалт, ард нийтийн хэлэлцүүлэг, уулзалтууд хийх
Корпорацууд	Жендерт суурилсан хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг ажилчдынх нь дунд явуулах	Хамтран ажиллах үүрэг хариуцлагын талаар маргаантай холбоодуудтай шууд ойртон нэгдэх

Зургадугаар шат: Кампанит ажлын үйл ажиллагаануудын загварыг гаргах.

Кампанит ажлын үйл ажиллагаа бүрийг тусдаа хүснэгтэнд байлуулснаар танд хүч буй зорилгод чинь хэрхэн хүрэхийг харуулна. Ил захидал, илтгэл болон бусад хүчин зүйлсүүдэд өмнөө тавьсан зорилтоо тодорхой тусгаж өгвөл эдгээр нь чухал ач холбогдол үзүүлэх нөлөөлөл болох юм.

Түүнчлэн бас заавал мөрдөн ажиллах хүчин зүйл байгаа гэдгийг санан засгийн газрыг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг багасгахад хариуцлага хандуулахад нь кампанит ажлын үйл ажиллагааг чиглүүлэх нь гол ажил юм. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь эдрээтэй бөгөөд маш олон үүдэл шалтгаан хариу шийдлүүдтэй. Заавал мөрдөх зүйлээ мөрдөн ажиллах нь кампанит ажлыг өргөжүүлээд зогсохгүй илүү амжилт бүтээлтэй болгоно.

Та үйл ажиллагаагаа төлөвлөхдөө идэвхитнүүд болон бусад хүмүүсийг оролцуулах хэрэгтэй. Тэд жишээ нь, зорилтот бүлгийнхэнд Эмнести Интернэшнлийн цахим хуудас: [//web.amnesty.org/actforwomen/](http://web.amnesty.org/actforwomen/) зэргээс материал авч захидал, и-мэйл бичих зэргээр олон нийтийг хамарсан кампанит ажлын үйл ажиллагаанд оролцож чадна. Та бас тэднийг өөрийн орны хуулинд тусгай өөрчлөлт оруулах талаар шийдвэр гаргагчдад хүсэлт тавихыг ятгаж болно.



Канадын Эмнести Интернэшнлийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажлын цахим хуудас: <http://www.amnesty.ca/stoptheviolence/>

Таны өмнө өргөн цар хүрээтэй олон үйл ажиллагаанууд нээлттэй байна. Эдгээр нь жагсаал цуглаан, и-мэйл захидал бичих, тараах материал, гарын авлага, судалгаа, веб хуудас, хэвлэлийн ярилцлага, зохион байгуулалттайгаар явган алхах, улс

төрчидтэй уулзалт хийх, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, өргөх бичиг гаргах, тайван жагсаал, тухайн хэргүүд дээр уриалга явуулах зэрэг үйл ажиллагаа байж болно. Энэ бүгд нь кампанит ажлыг урагш явуулахад хувь нэмэртэй.

Шинэ тактик байгууллага нь кампанит ажилд нөлөө үзүүлэх арга замын тухай мэдээлэл олж авах болон, мэдээлэл солилцох хэлэлцүүлгийг онлайнгаар хүний эрхийн байгууллагуудын дунд өрнүүлж, үр дүнтэй мэдээллүүдээр хангаж байгаа юм. Та тэдний цахим хуудсаар орж хойшид хэрэг болох мэдээллээ олж авах боломжтой. <http://www.newtactics.org/>

Таны кампанит ажлын үйл ажиллагаанд дараах зүйл орно.

- Нүүр тулсан үйл ажиллагаа: уулзалт, арга хэмжээ, чимээгүй жагсаал, сүлжээгээр ажиллах / шүүгчид/
- Шууд бус харилцаа холбоо: хэвлэл мэдээллийн ярилцлага, өмгөөлөгчийн мэдээлэл, утасны сүлжээ

Эмнести Интернэшнлийн бүтэц, секцүүд болон эмэгтэйчүүдийн байгууллагын кампанит ажлын жишээ:

АНУ-ын Сан Францискод эмэгтэйчүүдийн бүлэг ЭБХЯГТК-ийн гол агуулгыг засаг захиргааны хуулиндаа оруулахаар орон нутгийн захирамж гаргуулсан байна. Үүний нэг гол жишээг татвал, хотын төсвийг жендерийн мэдрэмжтэйгээр эргэн харах, жендэрийн тэгш байдалд чиглүүлсэн төсвийн хуваарилалтыг баталгаажуулах.

2004 оны 4-р сард Шведийн Эмнести Интернэшнл «ойрын хамаатан садны эрчүүдийн үйлдэж буй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл» гэсэн илтгэлийг хэвлэн гаргажээ.

Шведийн тус нөхцөл байдлыг гарган тавибал, ТББ-ууд, парламентын гишүүд, хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга, шинжээчдийн оролцсон семинарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан байна. Илтгэлүүд 80 гаруй сонин болон үндэсний радио телевизээр явсан байна.

Кампанит ажлын үйл ажиллагаанууд нь нэг өдөр 5-аас доошгүй хотод өрнөсөний дотор Стокхолм, Уппсала хотуудад хуримын цагаан даашинз өмссөн хүүхнүүдээр «Хүний өргөмжлөл» хийж 4 эмэгтэй тутмын нэг нь хуримын цэцгийн баглаандаа хар сарнай багцлан барьж хар гивлүүр нүүрэндээ унжуулсан нь гэрлэгсдийн доторхи хүчирхийллийг илэрхийлсэн байна.

Гтенбург болон Лундэд эмэгтэйчүүдийн эрхийн бүлгүүд болон гишүүд зуу зуун хүмүүсээс аварга том даавуун дээр гар бичүүлэн цуглуулсан байна. Илтгэл өрнүүлсний маргааш өдөр нь хууль зүйн яам дөрвөн яамнаас бүрдсэн ажлын хэсгийг гаргасан байна.

Жендерийн тэгш байдлын хэргийн сайд Мона Сахлын хэвлэл мэдээллээр: «Эмэгтэйчүүдийн эсрэг эрчүүдийн үйлдэж буй хүчирхийллийн тухай Эмнести Интернэшнэлийн илтгэл нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд хууль хэрэгжихгүй байгаа бөгөөд чанд хууль өгүүлэгдэж буйг харуулж байна. Хохирсон олон эмэгтэйчүүд нийгмээс тусламж дэмжлэг авч чадахгүй хохирч байна. Энэ бол хүлээн зөвшөөрөшгүй зүйл бөгөөд бид үүнийг өөрчлөнө.» гэж хэлсэн ба үүнийхээ дараа Эмнести Интернэшнл ажлын хэсгийн уулзалтанд уригдсан байна.

Канадын ЭИ орон нутгийн идэвхитнүүддээ зориулж онлайнгаар кампанит ажлын гарын авлагыг гарган тавьсан байна. Доорхи хаяг: <http://www.amnesty.ca/stoptheviolence/>. Үүнд: албан газар,

сургууль, дэлгүүр, номын сан, цагдаагийн газруудад үзүүлэх тараах ил захидлууд, тараах материал, плакатууд зэрэг багтсан байна. Жагсаасан санаанууд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар хэвлэл мэдээллээр явуулах, лааны гэрэлд шөнийн цуглаан хийх, чимээгүй цуглаан хийх, намууд эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын өдрийг тэмдэглэх, хүчирхийллээс ангид орон зайг бий болгох, гудамжны театр, кинон дээр нийтийн дунд хэлэлцүүлэг явуулах, мөн энэ сэдвээр урлагийн үзэсгэлэн гаргах зэрэг нь урам зориг, хөшүүрэг болох юм.

Непалын ЭИ Бутаны дүрвэгчдийн зуслангийн ойролцоох тус орны зүүн хэсэгт байдаг Дулабары гэдэг газар 100 оюутны дунд «Эмэгтэйчүүдийн ба гэр бүлийн хүчирхийлэл» сэдэвт ярилцлагыг зохион байгуулсан байна. Белгийн ЭИ «Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон шийдвэрлэх арга замууд» гэсэн онлайн таавар явуулсан байна. Английн ЭИ идэвхитнүүддээ зориулан тэдэнд үйл ажиллагааны уриалга кейсүүд, ил захидлууд, Англи улсын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи



мэдээллүүд, захидлууд, хэвлэлийн мэдээллүүдийг нэгтгэн хэвлэж идэвхтнүүдэд зориулсан багц хавтас болон орон нутгийн хэвлэл мэдээллийнхэнд илгээсэн байна. Английн ЭИ үндэстний кампанит ажлын стратегиа төлөвлөхийн өмнө гэр бүлийн хүчирхийлэл дээр ажиллах эмэгтэйчүүдийн бүлэгтэй хамтран өргөн хэмжээний зөвлөгөөн хийсэн байна. Түүнчлэн бас тэд хамтран ЭБХЯГТК-ийн сүүдэр илтгэлийг бичсэн байна. 2004 оны 2-р сард Туркийн мэргэжлийн хөл бөмбөгийн баг лигийн аварга шалгаруулах гол тэмцээн дээрээ /Туркийн ЭИ-д зориулан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажлын логотой цамцыг өмсөн тоглосон байна. Энэ нь кампанит ажилдаа хүмүүсийг, ялангуяа эрчүүдийг татан оролцуулах сайн үлгэр дууриал болох юм. Мексикд сураггүй болсон болон алагдсан эмэгтэйчүүдэд хүндэтгэл үзүүлсэн асар том ханын зураг зурж тавьсан байна.

Асуудлыг хэрхэн холбох вэ?

Дараах жагсаан гаргасан шатлалууд нь кампанит ажил гадаад болон дотоод оролцогчдоо хэрхэн холбож өгөх болон оролцогчиддоо хандсан мессэжийг яаж гаргаж ирэхэд тань туслах юм. Дараа нь та мессэжээ тараах хамгийн сайн арга хэрэгслийг сонгох хэрэгтэй, жишээ нь орон нутгийн сонинууд, олон нийтийг хамарсан уулзалтууд болон интернет ашиглаж болно.

Мөн зорьж буй оролцогчиддоо хүрч чадах хамгийн үр нөлөөтэй арга болон өөрт буй нөөц, ур чадварыг дотроо бод.

Та гол хэвлэл мэдээллийнхэнтэй түншлэл тогтоох, жишээ нь явуулж буй үйл ажиллагааныхаа талаар радио болон сонингийн тогтмол булан явуулж болно. Танай кампанит ажлын бүх харилцаа холбооны идэвхтнүүдэд эдгээр заавруудыг мөрдлөгө болгох хэрэгтэй.

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирогчдын ашиг сонирхолыг харилцаа холбооны төлөвлөгөө болон үйл ажиллагааныхаа гол зүйл болгон тавь. Эмэгтэйчүүдийн ТББ □уудтай нэн тэргүүнд хохирогчдод тусламж дэмжлэг үзүүлэх талаар зөвлөлд. Хохирогчдод тусламж үзүүлэхэд харилцаа холбооны идэвхитнүүд болон бусад зүйлс нь тэдний ашиг сонирхолд нийцсэн мэдрэмжтэй байх хэрэгтэй.

- Сануулга болохуйц кампанит ажлын материалууд нь цаашдаа өөрчлөлт авчрахад эсрэгээр нөлөөлнө. Оролцогчиддоо кампанит ажил нь бодитоор юуг өөрчилж чадах вэ гэдэг дээр жишээ гаргаж өг.

- Хэл: ямар үг сонгох вэ гэдэг дээр мэдрэмжтэй бай. Хүчирхийллийн буруутан биш, харин хохирогчийн талаар туршлагатай эмэгтэйчүүдийг хамааруул.

- Имиж: Хохирогчийг хүндэтгэн үзсэн бүрэн эрх дарх бүхий имижийг сонго. Намба төрхтэй байж идэвхи зүтгэлтэй эмэгтэйн дүртэй байх хэрэгтэй.

- Хэрэв төлөөлөгчид болон алдар цуутай хүмүүстэй ажиллавал тэд нарт ч бас энэ журмыг мөрдлөгө болгуулах хэрэгтэй. Та кампанит ажлынхаа холбох гол мессэжээ гаргаж ирэх хэрэгтэй. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажлын гол мессэж нь дараах зүйлсийг агуулсан байна.

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил юм. Энэ нь нуугдмал гэмт хэрэг. Аюулгүй байдалд амьдрах нь түгээмэл эрх болохоос давуу эрх биш юм. Хүний эрх нь сайн сайхныг авчраад зогсохгүй хууль тогтоомж, үүрэг хариуцлага, хохиролгүй болгох зэрэг олон зүйлсийг авчирдаг.

- Эрх баригчид хариуцлагатай байх ёстой. Эрх баригчид эмэгтэйчүүдийн аюулгүй байдалд баталгаа өгөх ёстой.

- Энэ таны гарт байна - бид үүнийг хамтдаа хийнэ. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох гэдэг нь чиг хандлагыг өөрчлөх ялангуяа хуулийг өөрчлөх тухай юм.

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг дуусгавар болгох гэдэг нь хувь хүний ялангуяа тогтсон ёс заншлын үүрэг хариуцлага юм. Та бүхний олон нийтийн ойлголт ухамсарыг дээшлүүлэхэд хандсан мессэж нь дараах 4 гол зүйлийг онцгойлсон байх ёстой.

- Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн адил тэгш байдлыг хүндэтгэсэн соёл нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хоорондох зөв харилцааны үндэс бөгөөд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд саад болдог.

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг шүүмжилж жендэрийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрсөн үлгэр дууриал бүхий эрчүүдийг дэмжсэн арга хэмжээ явуулж урам зориг өгөх

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл маш олон хэлбэртэй. Биеийн махбодод учруулсан хүчирхийлэлээс бусад нь ихэнхидээ далд нуугдмал байдаг учраас илрүүлэн гаргаж ирэхэд хамгийн хэцүү нь байдаг.



VIVA RIO нэртэй Бразилын ТББ (буугаа сонго - чөлөөтэй байна! Энэ таны бүү эсвэл би?) гэсэн үгтэй лого бүхий кампанит ажил өрнүүлсэн нь эмэгтэйчүүд нөхөртөө тэдний гарт буй бүү мэтээр дарамтлуулж байна гэдгээ илэрхийлсэн байна.

• Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын тулд эмэгтэйчүүдийг хүйс, арьс өнгө, ангийн давхарга, угсаа гарал, бэлгийн чиг хандлага, нас, хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхдаг нийгмийн чиг хандлагыг өөрчлөх хэрэгтэй.

Бүтээгдэхүүн хэрэглэгдэхүүн

Танай кампанит ажлыг үргэлжлэн явуулахад та бүхний зорилт, оролцогчид, нөлөөлөл, үйл ажиллагаа, идэвхитнүүд гэх мэт бүгдэд хамааралтай, тохирох арга хэрэгслүүдийг тодорхойлоо. Үүнд:

- Цахим хуудас
- Өнгөт танилцуулга
- Зурагт хуудас
- Ил захидал
- Захидал
- Видео кино
- Радиогийн булан (нэвтрүүлэг)
- Сонины тогтмол өгүүлэг
- Жүжиг
- Машин дээр наадаг сурталчилгаа
- Илтгэл, мэдээлэл

Алхам 7: Үнэлгээ ба хариу илтгэл

Өөрсдийн ажлаа шалгаж үнэлгээ өгөх нь бүх байгууллагуудад чухал зүйл байдаг. Үнэлгээ нь таны бий болгосон үр дүнг зохих ёсоор үнэлж бий болгосон сайн зүйлсийг харилцаа холбооны стратегид оруулж өгөхөд тань тусална. Кампанит ажлыг үе шаттайгаар үнэлэх нь зөв юм. Жишээ нь: үе шат буюу чухал үе бүрийн төгсгөлд кампанит ажлаа сайжруулах үнэлгээнээс гаргасан ашиг тустай мэдээллийг хэрэглэж байх. Та кампанит ажилдаа үнэлгээ хийхдээ дараах судалгааг авч байх хэрэгтэй.

- Та хийхээр зорьсон зүйлээ хийсэн үү?
- Та яг оновчтой зорилго, үйл ажиллагаагаа сонгосон уу?
- Та өөрчлөлт гаргаж чадсан уу?
- Таны үйл ажиллагаанаас гарах ойрын үр дүн юу вэ? Зорьсон зүйлдээ ямар нөлөө үзүүлсэн бэ? Таны зорилго биелэгдсэн үү? (Жишээлбэл, хууль өөрчлөгдсөн үү?)
- Хүлээж байгаагүй үр дүн гарсан уу?
- Зорьсон зүйлд тань өөр ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ?

Дүгнэлт

Өнөөдөр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн хамгийн ээдрээтэй асуудлуудын нэг болоод байна. Тоо томшгүй олон эмэгтэй бие мах бодь, бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийлэлээр өөрсдийн ойр дотны садан төрөл, гадаад дотоодын албан хаагчид, хувь хүмүүс, цагдаагийнхан, гэмт хэрэгтнүүд, цэргүүд болон зэвсэглэсэн этгээдүүдийн гарт өртөж байна.

Орон нутгийн болон үндэсний эрх баригчид гарсан хүчирхийллийг шалган мөрдөж, шийтгэх болон хүчирхийлээс ангид байх орчинг бүрдүүлж өгөхгүй, заавал мөрдөх зүйл дээр алдаа гаргаж байна.

Бүх дэлхий даяар эмэгтэйчүүд кампанит ажлын янз бүрийн арга хэрэгслүүдийн ашиглан практик, бодлого, хуулинд гэнэтийн өөрчлөлтүүдийг авчрах хүчирхийллийн эсрэг энэ урам зоригтой кампанит ажлыг удирдан жолоодоод байна.

Застийн газар, хотын захиргаа, орон нутгийн болон бусад эрх баригчид олон улсын хуулийн дагуу үүрэг хариуцлагаа хүлээхэд заавал мөрдлөгө болгох зүйлийг ашиглавал эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг зогсоох кампанит ажилд бас нэг нөлөө бүхий арга хэрэгсэл болно.

Хавсралт

Доорхи асуултууд нь танай оронд буй асуудлыг тодорхойлж кампанит ажлын зорилгыг гаргахад хэрэг болно.

Хүндэтгэх: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд улс орны хүлээх үүрэг хариуцлага

- Шоронгийн нөхцөл ямар байна?
- Эмэгтэйчүүд хориход ямар нөхцөл байдалд байна?
- Улсын асрамж болон асран хүмүүжүүлэх газарт буй охид ямар нйхцйл байдалд байдаг вэ?

Хамгаалах: Төрийн бус этгээдийн үйлдсэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд улс орны хүлээх үүрэг хариуцлага

- Төрийн бус этгээд болон бусад гэмт этгээдэд шийтгэл үзүүлэх хууль, засаг захиргаа , бодлогын тогтолцоо байдаг уу?
- Гэнэтийн үед гэр бүлийн хүчирхийллээс зугтаахад эмэгтэйчүүдэд боломж олгох хүрэлцэхүйц санхүүжилт байдаг уу?
- Эмэгтэйчүүд өмгөөлөл зөвлөгөөнд хамрагддаг уу?
- Гэр бүл бологсодын хоорондох хүчинг гэмт хэрэг гэж үздэг үү?
- Бэлгийн хүчирхийллийг бүх хуулинд гэмт хэрэг гэж үздэг үү?
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бусад ноцтой гэмт хэргүүдтэй харьцуулвал мөрдөн шалгах, ял хүлээлгэх байдал ямар түвшинд байна вэ?

Биелүүлэх

Хууль тогтоомжинд баталгаа гаргаж өгөх

Хууль зүй болон бодлогын тогтолцоо

- Эмэгтэйчүүдэд тусгайлан зориулсан хууль зүйн үйлчилгээ байдаг уу?
- Эмэгтэйчүүдэд хууль зүйн үйлчилгээний тусламж үзүүлдэг үү?
- Хүрэлцэхүйц, хангалттай нөөц санхүү байдаг уу?

Хуулийг өөрчлөх

- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан хуулиуд байдаг уу?

Хууль бус хамгаалууд

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн эрчүүдэд «уучлал» үзүүлдэг шашин болон соёлын уламжаал байдаг уу?
- «Нэр төрийн гэмт хэрэг»-ийг ноцтой гэмт хэргүүдтэй харьцуулвал өршөөл үзүүлэх нь илүү байдаг уу?

Иргэний хуулиудад чиглэх

- Иргэний хуулийн өөрчлөлт нь гэр бүлийн болон гэр бүлийн хүчирхийллийн хуулинд нөлөөлдөг үү?
- Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөө орон нутгийн, лесби зэрэг бүх бүлгийн эмэгтэйчүүдэд эдгээр хуулиуд эрх тэгш үйлчилж чаддаг уу?

Гэмт хэргийн талаарх сургалт судалгаа

- Цагдаагийн ажилтнууд болон бусад аюулгүйн албаныхан гэр бүлийн хүчирхийлэл, тухайлбал бэлгийн хүчирхийллийн үед яах, юу хийх талаар сургалтанд хамрагддаг уу?

- Тэд тогтмол сургалтанд хамрагдаж чаддаг уу?

- Цагдаагийн удирдах албан тушаалтнууд тогтмол сургалтанд хамрагдаж чаддаг уу?

Хохирогч бүрэн дүүрэн аюулгүй байж чаддаг уу?

- Хохирогч эмэгтэйчүүд хаана амьдардаг, аль орон нутгаас ирсэн зэргийг үл хайхран ялгаварлах явдал байдаг уу?

- Орон нутагт цагдаагийн дуудлага хожуу ирдэгтэй холбоотой хүчирхийлэлээс төдийгүй үхлийн аюулаас хамгаалах, туслах тал дээр хайхрамжгүй ханддаг уу?

- Хөдөө орон нутаг дахь олон нийтийн ойлголт ухамсрыг дээшлүүлэх тал дээр ямар хэмжигдэхүйц арга хэмжээ авсан бэ?

Дэмжих: Гарч буй хүчирхийлэлээс ангид байх эмэгтэйчүүдийн эрхийн хуулинд тусгай хөтөлбөр болон заавал мөрдлөгө болгох алхамуудыг оруулах

Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө

- Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө байдаг уу?

- Судалгааны үр дүнд тулгуурласан үндэсний стратеги гарсан уу?

- Энэ стратегийн хэрэгжилтэнд тооцох хариуцлага байдаг уу?

- Үйл ажиллагааны төлөвлөгөөний үр нөлөөг бий болгох механизмд тохирох үнэлгээ шинжилгээ байдаг уу?

- Эмэгтэйчүүдийн эрхийн байгууллага болон хүний эрхийн байгууллагуудтай зөвлөлдөн гаргасан үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө байгаа юу?

Статистик

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тархацын талаар тогтмол явагддаг статистик болон бусад мэдээ тоо баримт байдаг уу?

Төсөв

- Засгийн газар хүчирхийлэлд йртийж буй эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлагыг хангахад хүрэлцэхүйц нөөц санхүүтэй юу?

- Санхүүгийн нөөцийг бусад төстэй гэмт хэргүүдтэй харьцуулахад яаж хувиарлаж байна вэ?

Боловсрол болон олон нийтийн ойлголт ухамсрыг дээшлүүлэх

- Засгийн газар олон нийтийн ойлголт ухамсрыг дээшлүүлэх нөлөө бүхий кампанит ажлыг тогтмол явууладаг уу?

- Энэ нь янз бүрийн түвшингүүдэд хүрч ажиллахаар төлөвлөсөн урт хугацааны ажлын хэсэг үү?

- Тэд зорилтот бүлгээ зөв сонгож чадсан уу?

- Тэд ашиг тустай өөрчлөлтөнд чиглэж чадсан уу?

- Тэд олон нийтийн ойлголт ухамсарыг дээшлүүлэхэд туслаж чадах байгууллагуудтай хамтран ажиллаж, холбоо харилцаагаа өргөжүүлсэн үү?

- Тэд эрчүүдэд хандсан үйл ажиллагаа явуулж байна уу?